

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/200/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он	Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: Аав ээжийн тэнгэрлэг буян аудит ХХК-ийн Захирал: О.Бурмаа Утас: 99168735 Цахим хаяг: aetb.audit@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
4. Аудитын тайлан.....	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН СҮХБААТАР
СУМЫН 4 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.БАЯРЖАРГАЛ ТАНАА

2024.02.23 № СЭА-2024/202/НА-СТА-ТЦЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэг нь үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 89 хувьтай тайлагнагдсан байна.

Хоолны зардал 19,087.9 мянган төгрөгөөр, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийн зардал 61,624.7 мянган төгрөгөөр, сургалтын хэвийн үйл ажиллагаа хөтөлбөрийн зардал 31,356.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны А/324 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 2 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 22,631.3 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар тус бодлогын баримт бичигт нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тус цэцэрлэг нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилтын хүрээнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	88,596,924.53	199,660,127.22
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,235,537.71	112,598,514.56
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,235,537.71	112,598,514.56
3121	Төгрөг	1,235,537.71	112,598,514.56
31211	Төрийн сангийн харилцах	1,235,537.71	112,598,514.56
35	БАРАА МАТЕРИАЛ	87,361,386.82	87,061,612.66
354	Хангамжийн материал	87,361,386.82	87,061,612.66
35410	Бичиг хэргийн материал	-	364,000.00
35420	Аж ахуйн материал	85,720,966.82	85,896,112.66
35460	Хүнсний материал	838,920.00	-
35470	Бусад хангамжийн материал	801,500.00	801,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,104,469,078.84	1,107,883,732.69
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,104,469,078.84	1,107,883,732.69
392	Биет хөрөнгө	1,053,144,578.96	1,056,871,732.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,234,606,149.00	1,234,606,149.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(259,495,590.10)	(289,457,327.86)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	102,872,225.19	112,476,225.19
39206	Хуримтлагдсан элэгдэл	(63,607,060.81)	(88,168,989.24)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	82,174,944.55	82,174,944.55
39208	Хуримтлагдсан элэгдэл	(52,123,414.91)	(63,386,933.59)
39209	Зам, гүүрийн байгууламж	882,240.00	882,240.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(294,080.16)	(367,600.20)
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,489,450.00	67,096,550.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(747,154.80)	(1,370,396.16)
39217	Ном	2,386,871.00	2,386,871.00
393	Биет бус хөрөнгө	51,324,499.88	51,012,000.00
39301	Програм хангамж	2,021,100.00	2,021,100.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,708,600.12)	(2,021,100.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	51,012,000.00	51,012,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,193,066,003.37	1,307,543,859.91
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	50.00	369,800.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	50.00	369,800.00
413	Өглөг	50.00	369,800.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	50.00	341,800.00
4136	Бусад өглөг	-	28,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	28,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,193,065,953.37	1,307,174,059.91
51	Засгийн газрын хувь оролцоо	1,193,065,953.37	1,307,174,059.91
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	318,281,669.42	318,281,669.42
51101	Өмч:- төрийн	318,281,669.42	318,281,669.42
512	Хуримтлагдсан үр дүн	581,498,413.68	695,606,520.22
51210	Өмнөх үеийн үр дүн	(611,283,978.69)	581,498,413.68
51220	Тайлант үеийн үр дүн	1,192,782,392.37	114,108,106.54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	293,285,870.27	293,285,870.27
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,193,066,003.37	1,307,543,859.91

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,991,767,762.93	1,074,233,142.06
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,245,591,220.93	73,298,642.72
120	Нийтлэг татварын бус орлого	1,245,591,220.93	73,298,642.72
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,245,591,220.93	73,298,642.72
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого ҮХ	1,171,273,943.57	60,607,100.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого БМ	74,317,277.36	12,691,542.72
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	746,176,542.00	1,000,934,499.34
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	598,879,400.00	893,821,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	598,879,400.00	893,821,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,600,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,600,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	145,697,142.00	107,112,599.34
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	145,697,142.00	107,112,599.34
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	798,985,370.56	960,125,035.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	798,985,370.56	960,125,035.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	792,613,270.56	945,414,816.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	446,078,275.62	554,620,841.00
210101	Үндсэн цалин	336,245,138.91	390,165,881.42
210102	Нэмэгдэл	99,000,616.04	142,221,704.39
210104	Урамшуулал	10,832,520.67	22,233,255.19
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,958,069.67	69,069,879.23
210201	Тэтгэврийн даатгал	38,419,930.37	47,554,007.98
210202	Тэтгэмжийн даатгал	4,513,319.97	5,566,406.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,566,980.13	4,428,905.15
210204	Ажилгүйдлийн даатгал	856,969.92	1,047,341.97
210205	Эрүүл мэндийн даатгал	8,600,869.28	10,473,217.73
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,795,926.00	97,112,599.34
210301	Гэрэл, цахилгаан	5,083,644.00	7,808,549.81
210302	Түлш, халаалт	79,820,586.00	79,792,877.06
210303	Цэвэр, бохир ус	7,891,696.00	9,511,172.47
2104	Хангамж, бараа материалын зардал	4,947,710.54	11,243,896.88
210401	Бичиг хэрэг	138,400.00	-
210408	Бараа материал акталсны зардал	4,809,310.54	11,243,896.88
2105	Нормативт зардал	97,113,024.00	114,779,130.00
210502	Хоол, хүнс	97,113,024.00	114,779,130.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,500,000.00	9,900,000.00
210604	Урсгал засвар	15,500,000.00	9,900,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,227,300.00	1,410,873.92
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,227,300.00	1,410,873.92
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	78,992,964.73	87,277,596.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,690,800.00	19,019,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,377,300.00	1,461,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	68,924,864.73	66,796,446.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,372,100.00	14,710,219.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,372,100.00	14,710,219.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,372,100.00	14,710,219.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,192,782,392.37	114,108,106.54
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,192,782,392.37	114,108,106.54

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	746,176,542.00	1,000,934,499.34
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	746,176,542.00	1,000,934,499.34
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	598,879,400.00	893,821,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	598,879,400.00	893,821,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,600,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,600,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	145,697,142.00	107,112,599.34
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	145,697,142.00	107,112,599.34
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	742,821,004.29	879,967,522.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	742,821,004.29	879,967,522.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	736,448,904.29	865,257,303.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	446,232,675.29	554,620,841.00
210101	Үндсэн цалин	336,399,538.58	390,165,881.42
210102	Нэмэгдэл	99,000,616.04	142,221,704.39
210104	Урамшуулал	10,832,520.67	22,233,255.19
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,520,109.00	69,069,879.23
210201	Тэтгэврийн даатгал	37,981,969.70	47,554,007.98
210202	Тэтгэмжийн даатгал	4,513,319.97	5,566,406.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,566,980.13	4,428,905.15
210204	Ажилгүйдлийн даатгал	856,969.92	1,047,341.97
210205	Эрүүл мэндийн даатгал	8,600,869.28	10,473,217.73
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,795,926.00	97,112,599.34
210301	Гэрэл, цахилгаан	5,083,644.00	7,808,549.81
210302	Түлш, халаалт	79,820,586.00	79,792,877.06
210303	Цэвэр, бохир ус	7,891,696.00	9,511,172.47
2104	Хангамж, бараа материалын зардал	100,000.00	-
210404	Ном, хэвлэл	100,000.00	-
2105	Нормативт зардал	97,951,894.00	113,598,460.00
210502	Хоол, хүнс	97,951,894.00	113,598,460.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,500,000.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	23,500,000.00	10,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,356,000.00	1,340,110.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,356,000.00	1,340,110.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,992,300.00	19,515,413.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,352,300.00	14,989,113.92
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,640,000.00	4,526,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,372,100.00	14,710,219.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,372,100.00	14,710,219.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,372,100.00	14,710,219.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	3,355,537.71	120,966,976.85
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,120,000.00	9,604,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,120,000.00	9,604,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,120,000.00	9,604,000.00

222001	Тоног төхөөрөмж	-	9,604,000.00
223001	Бусад хөрөнгө	2,120,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(2,120,000.00)</u>	<u>(9,604,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,235,537.71	111,362,976.85
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,235,537.71
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,235,537.71	112,598,514.56

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 1-р сарын 1- нээрх үлдэгдэл	318,281,669.42	293,285,870.27	(611,283,978.69)	283,561.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	318,281,669.42	293,285,870.27	(611,283,978.69)	283,561.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	1,192,782,392.37	1,192,782,392.37
8	2022 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	318,281,669.42	293,285,870.27	581,498,413.68	1,193,065,953.37
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	318,281,669.42	293,285,870.27	581,498,413.68	1,193,065,953.37
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
16	Тайлант үеийн үр дүн	-	-	114,108,106.54	114,108,106.54
17	2023 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	318,281,669.42	293,285,870.27	695,606,520.22	1,307,174,059.91

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,002,169,000.00	889,571,522.49	112,597,477.51	88.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,002,169,000.00	879,967,522.49	122,201,477.51	87.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	987,458,700.00	865,257,303.49	122,201,396.51	87.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	630,046,300.00	554,620,841.00	75,425,459.00	88.0
210101	Үндсэн цалин	428,410,500.00	390,165,881.42	38,244,618.58	91.1
210102	Нэмэгдэл	176,560,100.00	142,221,704.39	34,338,395.61	80.6
210104	Урамшуулал	25,075,700.00	22,233,255.19	2,842,444.81	88.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,291,100.00	69,069,879.23	16,221,220.77	81.0
210201	Тэтгэврийн даатгал	57,997,600.00	47,554,007.98	10,443,592.02	82.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,823,200.00	5,566,406.40	1,256,793.60	81.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,458,400.00	4,428,905.15	1,029,494.85	81.1
210204	Ажилгүйдлийн даатгал	1,364,700.00	1,047,341.97	317,358.03	76.7
210205	Эрүүл мэндийн даатгал	13,647,200.00	10,473,217.73	3,173,982.27	76.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	97,112,600.00	97,112,599.34	0.66	100.0
210301	Гэрэл, цахилгаан	6,870,400.00	7,808,549.81	(938,149.81)	113.7
210302	Түлш, халаалт	79,792,200.00	79,792,877.06	(677.06)	100.0
210303	Цэвэр, бохир ус	10,450,000.00	9,511,172.47	938,827.53	91.0
2105	Нормативт зардал	132,686,400.00	113,598,460.00	19,087,940.00	85.6
210502	Хоол, хүнс	132,686,400.00	113,598,460.00	19,087,940.00	85.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	10,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	10,000,000.00	10,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,508,800.00	1,340,110.00	168,690.00	88.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,508,800.00	1,340,110.00	168,690.00	88.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,813,500.00	19,515,413.92	11,298,086.08	63.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,287,200.00	14,989,113.92	11,298,086.08	57.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,526,300.00	4,526,300.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,710,300.00	14,710,219.00	81.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,710,300.00	14,710,219.00	81.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,710,300.00	14,710,219.00	81.00	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	9,604,000.00	(9,604,000.00)	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	9,604,000.00	(9,604,000.00)	-
222001	Тоног төхөөрөмж	-	9,604,000.00	(9,604,000.00)	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,002,168,999.34	1,000,934,499.34	1,234,500.00	99.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	893,821,900.00	893,821,900.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	893,821,900.00	893,821,900.00	-	100.0

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	107,112,599.34	107,112,599.34	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	107,112,599.34	107,112,599.34	-	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,234,500.00	-	1,234,500.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,234,500.00	-	1,234,500.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,235,537.71	(1,235,537.71)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	112,598,514.56	(112,598,514.56)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	34	34	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	11	11	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	22	22	-	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1	1	-	100.0
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	1	1	-	100.0
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага		270	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	34	34		100.0
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	21	21	-	100.0
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1	1	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	12	12	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэг нь “Хүүхдийн болон багшийн бүх талын тасралтгүй хөгжлийг хангахад хамтран ажиллах” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Багшийн хөгжил
- Сургалтын үйл ажиллагаа
- Хүүхэд бүрийг зөв хүсэл зорилготой өөрийгөө хөгжүүлж , бүтээлчээр суралцах чадвартай иргэн болгон хөгжүүлнэ гэсэн зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Боловсролын ерөнхий хууль 2023 оны 7 дугаар сарын 7-нд шинэчлэгдэн батлагдсан,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,*
- *БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд:
1."ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх",
2."Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом,наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 114,477.9 мянган төгрөгөөр буюу 9,6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,235.54	112,598.51	111,362.98
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	87,361.39	87,061.61	(299.77)
Үндсэн хөрөнгө	1,104,469.08	1,107,883.73	3,414.65
Нийт хөрөнгө	1,193,066.00	1,307,543.86	114,477.86
Өр төлбөр	0.05	369.80	369.75

Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,193,065.95	1,307,174.06	114,108.11
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,193,066.00	1,307,543.86	114,477.86

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн данс 112,598.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 7.9-д заасны дагуу тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлтийг төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасанатай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 880,776.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 106,112.6 мянган төгрөгөөр, нийт 986,889.1 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвийн санхүүжилтийг 264,936.7 мянган төгрөгөөр бууруулж 615,839.8 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 106,112.6 мянган төгрөгөөр тус тус нийт 721,952.4 мянган төгрөгийн санхүүжилтийг баталсан байна.

Төсөв хүрэлцэхгүй шалтгаанаар 2023 оны 1,2,6,11,12-р саруудад нийт 6 удаа төсвийн зохицуулалт хийгдэж, улсын төсвийн санхүүжилтийг 279,217.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт 895,057.4 мянган төгрөг, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 1,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 107,112.6 мянган төгрөг нийт **1,002,170.0** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 895,057.4 мянган төгрөгийг, орон нутгийн төсвөөс 107,112.6 мянган төгрөг, нийт **1,002,170.0** мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 889,571.5 мянган төгрөг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 889,571.5 мянган төгрөг буюу 89.0 хувьтай байгаа нь хоолны зардал 19,087.9 мянган төгрөгөөр, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийн зардал 61,624.7 мянган төгрөгөөр, сургалтын хэвийн үйл ажиллагаа хөтөлбөрийн зардал 31,356.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл
/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувиар
	Улсын төсвөөс санхүүжих				
1	81605 - Эрүүл мэндийг дэмжих	2,264.10	2,158.00	106.10	95.3
2	81807 - Цэцэрлэгийн хүүхдийн хоол	132,686.41	113,598.46	19,087.95	85.6
3	81816 - Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	4,684.70	4,674.00	10.70	99.8
4	81823 - Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	2,263.10	1,850.00	413.10	81.7
5	81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	555,665.50	494,040.83	61,624.67	88.9
6	81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагаа	197,493.63	166,137.63	31,356.00	84.1
	Дүн	895,057.44	782,458.92	112,598.51	87.4
	Орон нутгийн төсвөөс санхүүжих				
7	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	107,112.60	107,112.60	-	100.0
	НИЙТ	1,002,170.04	889,571.52	112,598.51	88.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “*Чиглэл хүргүүлэх тухай*” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Шууд худалдан авах босго үнээс давсан /2023 оны анх батлагдсан төсвөөр/ 132,686.4 мянган төгрөгийн хоол, хүнсний материалын худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

Тодруулбал мах, хүнсний материалыг Галил этоос ХХК, Царам мөрөн ХХК, Өгөөж ундрам ХХК, Алтан тариа ХХК, иргэн Ч.Ягаан, Ц.Оюун-эрдэнэ, Д.Цэцэгмаа нартай тус тус гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл

баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Аав ээжийн тэнгэрлэг буян аудит” ХХК-ийн аудитор Д.Даваасүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал О.Бурмаа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Аав ээжийн тэнгэрлэг буян аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 798,985.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 7,989.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Гар утасны зардал гаргаагүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн системд 27 төрлийн 170 мэдээлэл байршуулахаас 2 төрлийн мэдээллийг хугацаа хоцроож, 2 төрлийн мэдээллийг мэдээлээгүй байна. Үүнд:

Хугацаа хоцроосон мэдээллүүд:

- Дараа жилийн төсвийн төсөл
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан

Оруулаагүй мэдээллүүд:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл-Хөтөлбөр, зориулалт
- Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд алдаа зөрчил давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, ...бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэж заасны дагуу тус цэцэрлэгийн нягтлан бодогч С.Алтанцэцэгт **хариуцлага тооцуулах** албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнаагүй, шууд худалдан авах босго үнээс давсан 132,686.4 мянган төгрөгийн хоол, хүнсний материалын худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална”, 48 дугаар зүйлийн 48.5-т “Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ”, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн 1. *Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-70.0 сая төгрөг*, 2. *“Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0 сая төгрөг”* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнах, хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсны үндсэн дээр худалдан авалтыг хийж гүйцэтгэх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн тус цэцэрлэгийн худалдан авах ажиллагаа нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус цэцэрлэгийн 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар худалдан авалтыг цахим баримтаар баталгаажуулаагүй зөрчил илэрч албан шаардлага өгөгдсөнийг биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	4490.3	1	4490.3	100
Нийт дүн		4490.3		4490.3	

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **369.8** мянган төгрөгийн зөрчил¹ илэрч зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага, зөвлөмж хүргүүлээ.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Албан шаардлага

1.Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас хоолны зардлын 369.8 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр тооцоо, гүйлгээг гарахаас өмнө нь хянан баталгаажуулж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, өр төлбөрийг барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

1. Цалин хөлстэй холбоотой

1. Илрүүлэлт: Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн үндсэн орон тоонд нягтлан бодогчоор ажиллаж буй С.Алтанцэцэгийг тус цэцэрлэгт зэрэгцсэн хөдөлмөрөөр нягтлан бодогчоор ажиллуулан, цалинжуулж / үндсэн цалингийн 100.0 хувиар тооцож / байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь "Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээтэй ажилтны нийт ажлын цаг энэ хуулийн 84.4 -т заасан ажлын цагийн дээд хязгаарт багтах ёстой бөгөөд үүнд ажилтан, үндсэн болон зэрэгцсэн ажил олгогч тус тус хяналт тавина", 84 дүгээр зүйлийн 84.4 дэх "Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: 2 байгууллагад зэрэгцээ хөдөлмөрөөр нягтлан бодогчийн албан тушаал эрхлүүлж буй зөрчлийг таслан зогсоож, зайлшгүй тохиолдолд цалинг өдрийн 4 цагаар бодож, 50.0 хувиас хэтрүүлэхгүй байх.

2. Үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалттай холбоотой

Илрүүлэлт: Бараа материалын тооллогыг жилд 1 удаа хийсэн байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2-д " түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/;" гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын тооллогыг хуульд заасны дагуу зохион байгуулж байх.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 - ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өр төлбөр үүсгэсэн	1	369.8			1	369.8						
Бараа материалын тооллогыг хуульд заасны дагуу зохион байгуулаагүй	1	-					1	-				
Нягтлан бодогчийг зэрэгцээ хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулсан	1						1					
Дүн	3	369.8			1	369.8	2	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд мэдээлбэл зохих 2 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг мэдээлээгүй	1				1			
Дүн	1				1			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1						1	

Дүн	1							
Нийт дүн	2				1		1	